

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССИЙН АЖИЛЛАГААН ДАХЬ МЭРГЭЖИЛТНИЙ ОРОЛЦОО НЬ ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУЛГАМДСАН АСУУДЛЫН НЭГ БОЛОХ НЬ

PARTICIPATION OF SPECIALISTS IN CRIMINAL CASE SETTLEMENT PROCESS IS ONE OF URGENT PROBLEMS IN LAW ENFORCEMENT AGENCIES' COOPERATION



Т.ОЧИРБАТ

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шинжилгээний
бүртгэл, мэдээллийн хэлтсийн дарга, ХСИС-ийн докторант

OCHIRBAT T.

Doctoral candidate of LEU, Head of Registration and
Information Unit, National Institute of Forensic Science

Товч утга: Эрүүгийн байцаан шийтгэх бүхий л ажиллагаанд мэргэжилтний оролцоо байсаар байдаг бөгөөд үзлэг, туршилт зэрэг тодорхой ажиллагааг явуулахад мэргэжилтнийг оролцуулахаар шууд заасныг эс тооцвол байцаан шийтгэх ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулах асуудал зохицуулалтгүй байна.

Мэргэжилтэн, түүний үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээ Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжид зайлшгүй байх шаардлагатай болохыг зөвхөн онолын хүрээнд судлаачид бий болгоогүй, практик үйл ажиллагаа, түүнд тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлаас үүсэлтэй гэдгийг дурдах нь зүйтэй юм.

Энэхүү судалгааны ажлаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулах эрх зүйн зохицуулалт, практикт хэрэгжиж байгаа байдал, тулгамдаж буй зарим асуудал, түүнээс гарах арга замыг эрэлхийлэхийг зорьлоо. Эдгээр асуудлыг шийдвэрлэснээр хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааны нэгэн хэлбэр төгөлдөржих боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Abstract: In all process of criminal case settlement, there is always participation of specialists. However, legal regulation is very weak on participation of specialists in criminal case settlement process, except participation in some certain activity such inspection and experiment.

The conclusion, that Mongolian Law on Criminal Case Procedure needs provisions regulating specialists and their activities, is not produced from mere theory but from practical application and difficulties in real life.

This study is aimed to analyze on legal regulation of specialist participation in criminal case settlement process, its practical applications and some urgent problems, and seeks ways to solve such problems. I believe that if these problems are solved, cooperation of law enforcement agencies will be improved.

Түлхүүр үгс: Шинжээч, мэргэжилтэн, шинжээчийн дүгнэлт, шинжилгээний магадлагаа, мэргэжилтний дүгнэлт, тусгай мэдлэг, тусгай чадвар.

Key words: Expert, specialist, expert report, analysis result, specialist report, special knowledge, special skill.

Ключевые слова: эксперт, специалист, заключение эксперта, заключение специалиста, специальные знания, специальные познания.

Удиртгал

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үед болж өнгөрсөн үйл явдал, ул мөр, хүмүүсийн үйлдэл зэргийг танин мэдэх, үнэлж дүгнэхэд тусгай мэдлэгийн салбаруудад тулгуурлах шаардлага байнга тулгардаг. Харин тусгай мэдлэгийг шаардлагатай үед ашиглах боломж, нөхцөлийг хууль тогтоомж, байгууллагуудын хамтын ажиллагаа, оновчтой бүтэц зохион байгуулалт, чадварлаг боловсон хүчний хангалтаар шийдэж чадаж байна уу эсвэл үгүй юу гэдэгт судалгаа хийж үнэлэлт дүгнэлт өгөх нь судлаачдын нэг үүрэг юм.

Улсын хэмжээнд 1960-1980 онд 3-6 мянган гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 1990 он гараад 9-20 гаруй мянган гэмт хэрэг гарах болж, энэ үзүүлэлт огцом өссөн байна.¹ Өнгөрсөн жил буюу 2013 онд 25362 гэмт хэрэг бүртгэгдсэн, өөрөөр хэлбэл, 10000 хүн ногдож буй гэмт хэрэг 87,4 байгаа нь бусад улс орны статистик үзүүлэлттэй харьцуулахад сэтгэл сэрдхийлгэм тоо юм. Тухайлбал, Норвеги улсад хүнийг санаатайгаар алсан гэмт хэрэг 100 000 хүн тутамд 0,6 гарсан бол Монгол Улсын хувьд 8,7 ногдож байна.¹ Эдгээр хэргийн ихэнх хувь нь нууц, далд аргаар үйлдэгдсэн бөгөөд 30 гаруй хувь нь хулгай, хүн амины хэргүүд эзэлж байна. Энэ бүхнийг илрүүлэх, шийдвэрлэх явдал нь хэргийн газрын үзлэгийг хэн, хэрхэн зохион байгуулж, ямар техник хэрэгсэл, тусгай мэдлэг, чадвар ашигласнаас шалтгаалдаг болох нь тодорхой.

Мөн нотлох баримтын нэгэн эх сурвалж болох шинжээчийн дүгнэлт гаргуулах явдал тасралтгүй өссөн үзүүлэлттэй² байна. Зөвхөн шүүх эмнэлгийн шинжилгээтэй холбоотой зарим тоо баримт дурдвал, 2014 онд 3742 цогцост мөрдөн байцаагчийн тогтоолоор задлан шинжилгээ хийж, 31535 хүний биед буюу Монгол Улсад дөнгөж төрснөөс эхлээд 100 хүн тутмын 1-д нь гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ³ хийсэн байна.

Дээрх тоо баримтаар дурдсан ажиллагаа (хэргийн газрын үзлэг, шинжилгээ)-г явуулахад эрх зүйн зохицуулалт, хууль хэрэглээний практик, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, бүтэц зохион байгуулалттай холбоотой тодорхой хүндрэл бэрхшээлүүд байнга тулгардаг. Үүний шалтгаан, нөхцөлийг судлан, түүнийг даван туулах шинэ санаа олох, амьдралд нэвтрүүлэхийг хичээх зайлшгүй шаардлага төрийн байгууллагын ажилтан, эрдэмтэн, судлаач, сонсогч, оюутан хэн бүхний өмнө тулгарч байна. Энэ судалгааны ажлаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулах эрх зүйн зохицуулалт, практикт хэрэгжиж байгаа байдал, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаанд эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор тулгамдаж буй зарим асуудал, түүнээс гарах арга замыг эрэлхийлэхийг зорьлоо.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжид мэргэжилтний эрх зүйн байдлыг тусгасан нь:

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулах асуудал нь аливаа хэргийг шийдвэрлэхэд “тусгай мэдлэг”, “тусгай чадвар”-ыг⁴ ашиглах явдалтай зайлшгүй холбогдоно. Тусгай мэдлэгтэй хүнийг оролцуулах талаараа мэргэжилтнийг оролцуулах, шинжээчээр томилох асуудал хоорондоо нийтлэг

¹ Т.Очирбат. Шинжлэн магадлахуй. УБ.2014., 69 дэх тал.

² Т.Очирбат. “Монгол улсын шүүх шинжилгээний байгууллага ба гадаад орнуудын шүүх шинжилгээний байгууллагууд” сэдэвт судалгааны дэд тайлан. УБ. 2013. 52 дахь тал.

³ Шинжилгээний байгууллагад 2014 онд 65 163 шинжилгээ хийжээ.

⁴ Шүүх шинжилгээний статистик 2014. УБ., 2015. 6 дахь тал.

талтай боловч байцаан шийтгэх ажиллагааны үе шат, нотлох баримтын эх сурвалж болох эсэх, шинжилгээ хийж хариу өгөх хэлбэр талаараа ялгаатай. Эрүүгийн процессийн ажиллагаанд оролцогч, мэргэжилтний эрх зүйн байдлыг эрх зүйн соёл өндөртэй улс орнууд процессийн хууль тогтоомжоор тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал, ОХУ-ын Эрүүгийн процессийн хуульд тусгай мэдлэг бүхий субъектүүд болох мэргэжилтэн⁵, мөрдөн байцаагч-криминалист⁶, шинжээч⁷ гэсэн оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагыг заасан хэм хэмжээ тогтоосон. Харин мэргэжилтний дүгнэлт нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх эсэх асуудал нь тухайн улс орны эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь бодит үнэнийг тогтоох эсвэл мэтгэлцэх зарчимд тулгуурлан явагдаж байгаа эсэхээс ихээхэн хамааралтай⁸ ажээ.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар "мэргэжилтэн"-ийг бусад оролцогч⁹ гэж үздэг бөгөөд мөрдөн байцаалтын тодорхой ажиллагаанд, тухайлбал, үзлэг (127.5), туршилт (131.2) хийхэд уг хэрэгт хувийн сонирхолгүй мэргэжилтнийг урьж оролцуулж болохоор заасан. Мөн Шүүхийн шинжилгээний тухай хуульд "шүүхийн шинжилгээний мэргэжилтэн" гэж криминалистикийн болон эмнэлгийн тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд мэргэжилтнээр оролцох эрх бүхий, шинжилгээний байгууллагын ажилтан гэж тодорхойлжээ. Энэ нь зөвхөн шүүхийн шинжилгээний байгууллагад алба хааж байгаа мэргэжилтнийг хэлж байгаа бөгөөд "эрх бүхий" гэдэг нь хэргийн газрын үзлэгээр ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх эрх олгох сургалтад хамрагдаж сертификат авсан болохыг илэрхийлдэг. Мөн шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээч, мэргэжилтэн ажиллана¹⁰ гэж заасан бөгөөд мэргэжилтэн ямар эрх, үүрэгтэй талаар тус хуульд тодорхой заагаагүй байна.

Зөвхөн "мэргэжилтэн" гэсэн үгийг шууд ойлгогдох хэлбэр талаас нь авч хэрэглэсэн, өөрөөр хэлбэл, түүний агуулга, мөн чанараар тодорхойлогдоогүй заалт Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шинжилгээний тухай хуульд хоорондоо уялдаа холбоогүй байдлаар орсон гэж үзэж болохоор байна. Мөн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд барьцаалагчтай хэлэлцээр хийх, компьютер хураан авах, дүрс бичлэг хийх, насанд хүрээгүй хүнд холбогдох хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, гал түймрийн улмаас учирсан хохирлыг тогтоох, цацрагийн идэвхжил бий болсон эсэх, хорт хийн болон галын аюулын нөлөөлөл буурсан эсэхийг тогтоох зэрэг тодорхой ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулахаар заасан. Харин уг журамд полиграф ашиглах мэргэжилтнийг тодорхойлохдоо "мэргэжилтэн гэж полиграфын төхөөрөмж ажиллуулах, ашиглах сургалтад хамрагдаж, эрх олгогдсон алба хаагчийг хэлнэ" гэсэн байх бөгөөд "Мэргэжилтэн полиграф ашигласан үндэслэл, зорилго, арга, техник хэрэгслийн болон сэтгэл хөдлөлийн хэмнэлийн үзүүлэлт, үр дүнгийн тухай магадалгаа бичнэ"¹¹ гэж заасан нь Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч мэргэжилтнийг бодит утгаар нь тодорхойлох оролдлого хийсэн нэг жишээ болжээ.

Ер нь эрүүгийн байцаан шийтгэх бүхий л ажиллагаанд мэргэжилтний оролцоо

⁵ "специальные знания", "специальные познания", "special skills" "special knowledge"

⁶ УПК РФ. Ст.168

⁷ УПК РФ. Ст.40.1.

⁸ УПК РФ. Ст.195

⁹ Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд бодит үнэнийг тогтоох, мэтгэлцэх зарчмыг хуульчлан тусгасан нь. Шударга ёс сэтгүүл. 2011. 2 (7). 3 дахь тал.

¹⁰ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. Нэр томъёоны тодорхойлолт.

¹¹ Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хууль. 41 дүгээр зүйл.

байсаар байдаг бөгөөд дээр дурдсан үзлэг, туршилт зэрэг тодорхой ажиллагааг явуулахад мэргэжилтнийг оролцуулахаар шууд заасныг эс тооцвол байцаан шийтгэх ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулах асуудал зохицуулалтгүй байна. Эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагаануудад мэргэжилтэн оролцсоор байгаа боловч мэргэжилтний эрх, үүрэг, хариуцлагын талаарх хуулийн зохицуулалт тодорхойгүй байгаа шалтгаан нь мэргэжилтний эрх зүйн байдлыг судлах, хууль тогтоомжийн шаардлагатай хэм хэмжээг бий болгох, хууль хэрэглээний зөв практикийг хэвшүүлэх ажилд анхаарал хандуулаагүй явж ирсэнтэй холбоотой.

Харин Монгол Улсын болон бусад улсын эрүүгийн процессийн хууль тогтоомжид мэргэжилтний эрх зүйн байдал хэрхэн туссан талаар доктор Бө.Бат-Эрдэнэ өөрийн судалгааны ажлыг бүхэлд нь чиглүүлэн онол, эрх зүйн талаас нь иж бүрэн судалгаа хийсэн бөгөөд судалгааны дүнгээс үндэслэн өөрийн хувилбарыг хуулийн төсөл хэлбэрээр гаргаж санал болгосон бол доктор Ж.Болдбаатар, Б.Бат-Эрдэнэ, Ц.Гантулга, Т.Бямбаа, Б.Жаргалсайхан нар судалгааны ажлынхаа хүрээнд дээрх сэдвийг хөндсөн байна.

Доктор Бө.Бат-эрдэнэ “Монгол Улсын процессийн хууль тогтоомжид мэргэжилтний эрх зүйн байдлыг тодорхой бус заасан, үзлэг хийх, мөрдөн байцаалтын туршилт явуулахад мэргэжилтнийг оролцуулж болохоор хуульчилсан боловч эдгээр ажиллагаанд оролцох үедээ баримтлах эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой асуудлыг дурдаагүй байна. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн хэм хэмжээнд мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад оролцох мэргэжилтний оролцооны эрх зүйн үндсийг тодорхойлсон байдал бараг байхгүй байгаа учраас Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд мэргэжилтний үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн урьдчилсан нөхцөлийг бий болгох шаардлагатай гэдэг нь эргэлзээгүй. Дүгнэж хэлэхэд Монгол Улсын шүүн таслах ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулан тусгай мэдлэг ашиглах чухал нөхцөл (момент) зохицуулагдаагүй үлдсэн байна”¹² гэжээ.

Доктор Б.Бат-Эрдэнэ “16 нас хүрээгүй ялгадагчийг, мөн 18 хүртэлх насны этгээдийг оюун ухаан нь гүйцэд хөгжөөгүй гэж үзээд түүнийг байцаахад сурган хүмүүжүүлэгчийг оролцуулж байгаа нь мэргэжилтнийг оролцуулж байгаагийн нэг хэлбэр мөн”¹³ гэж үзсэн байна.

Мөн доктор Ж.Болдбаатар “Эрүүгийн байцаан шийтгэх хуульд мэргэжилтэн гэж хэн болох, түүний эрх зүйн байдал ямар болохыг тусгайлан заагаагүй. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн уг хийдэл нь полиграфыг байцаан шийтгэх ажиллагааны явцад тухайлбал, байцаалтын үед ашиглах эрх зүйн үндсийг бүрдүүлэх боломжийг хязгаарлаж байна”¹⁴ гэсэн бол доктор Б.Жаргалсайхан мэргэжилтний эрх, үүргийг шинжээчийнхтэй төстэйгээр оруулах, тухайлбал, зохих тусгай мэдлэгийг эзэмшээгүй бол ЭБША-нд оролцохоос татгалзах, эрх бүхий субьектын зөвшөөрлөөр ЭБША-ны оролцогчдод асуулт тавих, өөрийн оролцсон ЭБША-ны тэмдэглэлтэй танилцаж санал оруулахыг шаардах, эрх бүхий субьект түүний эрхийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэл гаргасан бол гомдол гаргах эрхтэй талаар, мөн мөрдөн байцаалтын нууц задруулахыг хориглосон заалт оруулах шаардлагатай”¹⁵ гэсэн санал гаргажээ.

¹² Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. 2010. КОД 302.

¹³ Бө.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь мэргэжилтэн, шинжээчийн эрх зүйн байдал. Дисс. М., 2009. 58 дахь тал.

¹⁴ Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Ерөнхий анги. УБ., 2004. 99 дэх тал.

¹⁵ Ж.Болдбаатар. Гэмт хэрэг илрүүлэхэд полиграф ашиглах онол, арга зүйн асуудал. Дисс. УБ., 2013. 55 дахь тал.

Процессийн ажиллагааны оролцогч нь онолын хувьд хэд хэдэн шалгуур шинжийг агуулсан байх ёстой гэж доктор Д.Баярсайхан үзсэн байх бөгөөд эдгээр шалгуур шинжийн нэг нь "Эрх зүйн байдлыг нь хуулиар тусгайлан зохицуулсан байх" явдал¹⁶ юм. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч "мэргэжилтэн"-ий хувьд энэ шалгуур шинж үгүй байна.

Мэргэжилтэн, түүний үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээ Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжид зайлшгүй байх шаардлагатай болохыг зөвхөн онолын хүрээнд судлаачид бий болгоогүй, практик үйл ажиллагаа, түүнд тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлаас эх үндэстэй гэдгийг дурдах нь зүйтэй юм.

Хууль тогтоомж, хууль хэрэглээний практикаас дүгнэлт хийсний үндсэн дээр процессийн ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулах хэм хэмжээг бүлэглэж үзэж болохоор байна. Үүнд:

- Мэргэжилтнийг оролцуулахаар шууд заасан хэм хэмжээ (үзлэг, мөрдөн байцаалтын туршилтад мэргэжилтнийг урьж оролцуулж болно);

- Мэргэжилтнийг оролцуулахаар шууд бус заасан хэм хэмжээ (сурган хүмүүжүүлэгч, шинжээч-эмч гэх мэт);

- ЭБША-ны зарим оролцогчдын хавсарга үүрэг байдлаар оруулсан хэм хэмжээ (шинжилгээний магадлагаа гаргах¹⁷, мөрдөн байцаагч үзлэг хийх гэх мэт).

Судалгаанаас дүгнэвэл Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжид мэргэжилтний талаар нэгдмэл ойлголт бий болгоогүй, мэргэжилтнийг мөрдөн байцаалтын болон шуурхай эрэн сурвалжлах ажиллагаанд оролцуулах үед үүсэх харилцааг тодорхой зохицуулсан хэм хэмжээг бий болгоогүй, цаашилбал мэргэжилтэн өөрийн тусгай мэдлэгийн хүрээнд үзлэг, шинжилгээ хийж магадлагаа гаргах (мэргэжилтний дүгнэлт) асуудлыг зохицуулаагүй байна.

ЭБША дахь мэргэжилтний оролцоо, өнөөгийн практик

Хэдийгээр эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжид мэргэжилтний эрх зүйн байдлыг тодорхой заасан хэм хэмжээ байхгүй боловч мөрдөн байцаалтын практикт мэргэжилтнүүдийн оролцоо өргөн байдаг. Ялангуяа үзлэг, мөрдөн байцаалтын туршилт хийх ажиллагаанд бараг бүгдэд нь мэргэжилтэн оролцсон байна.¹⁸ Хүн нас барсан бүх хэргийн газрын үзлэгт мэргэжилтэн-шинжээч эмч оролцжээ.¹⁹

Хэдий тийм боловч хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцож байгааг шинжээчээр оролцож байгаа мэтээр ойлгодог, тэр байтугай үзлэгийн тэмдэглэлд "шинжээч" гэж бичээд гарын үсэг зуруулдаг практик тогтсон нь харамсалтай. Энэ нь хэлбэрийн зүйл төдий боловч эрх зүйн үр дагавар бий болгох талтай. Доктор Б.Жаргалсайханы үзэж байгаагаар "нэгэнт хуульд заагаагүй үүрэг хүлээн үзлэгт оролцсон шинжээчийн тусгай мэдлэг, хэрэгсэл ашиглан илрүүлж, бэхжүүлсэн мөр, боловсруулсан асуулт, өгсөн зөвлөгөө хуулийн хүчин төгөлдөр эсэх, үзлэгт оролцсон шинжээч өөрийн илрүүлсэн мөр, зүйлд шинжилгээ хийж болох эсэх, ийм дүгнэлт хүчин төгөлдөр эсэх зэрэг асуулт практикт шийдлээ хүлээсээр байна".²⁰

Үүнийг доктор Бө.Бат-Эрдэнэ "Монгол Улсын байцаан шийтгэх эрх зүйд

¹⁶ Б.Жаргалсайхан. Экспертийн дүгнэлт, түүний эрх зүйн зохицуулалт. Илтгэл. 2010

¹⁷ Д.Баярсайхан. Эрүүгийн процессийн эрх зүй. УБ., 2014. 110 дахь тал.

¹⁸ Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хууль. 6 дугаар зүйл.

¹⁹ Шүүх шинжилгээний статистик - 2013, 2014. УБ., 2014. 34 дэх тал.

²⁰ Бө.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд дахь мэргэжилтэн, шинжээчийн эрх зүйн байдал. Дисс. М., 2009. 59 дэх тал.

тусгай мэдлэгийг ашиглах тогтолцоо (институци) хангалттай хөгжөөгүй байгаа нь шинжлэх ухааны асуудал болж байна. Эдгээр асуудал нь:

- *Нэгдүгээрт*, “тусгай мэдлэг”, “шүүх шинжээч”, “мэргэжилтэн”, “шүүх шинжилгээ” гэх мэт үндсэн ойлголтын тогтсон онолын боловсруулалт байхгүй;

- *Хоёрдугаарт*, дээрх ойлголтод хамаарч буй нэр томьёог буруу ташаа ашиглаж байна. Бидний бодлоор Монгол Улсын хууль тогтоомжид “шинжээч”, “мэргэжилтэн” гэсэн ойлголтоор хэрэглэж буй нэр томьёо нь алдаатай байгаагаас хуулийн хэм хэмжээг буруу тайлбарлах, шүүх шинжилгээ явуулахад процессийн алдаа гаргахад хүргэж байна...”²¹ гэж дүгнэжээ.

Нөгөө талаар Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 127.5-д “Үзлэг хийхэд уг хэрэгт хувийн сонирхолгүй мэргэжилтэнг урьж болно” гэж заасан боловч хууль хэрэглээний буруу практикаас үүдэлтэйгээр хэт хавтгайруулсан хандлага бий болгож байна. Өөрөөр хэлбэл, хэргийн газрын үзлэг хийх бүрт “шинжээчийг” (хуулиар бол “мэргэжилтэн”) оролцуулдаг гэсэн буруу практик уламжлал болон тогтсоноос болж гэмт хэрэг илрүүлэх ажилд тодорхой бэрхшээл учирч, байгууллага хоорондын үл ойлголцол бий болох нөхцөл бий болгож байгаа жишээ цөөнгүй ажиглагдаж байна. Үүнийг прокурор, цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллага, эдгээр байгууллагын ажилтнууд хоорондын харьцаагаараа, өөрөөр хэлбэл бичигдээгүй хуулиар зохицуулсаар ирсэн нь нууц биш юм. Харин шинээр боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн барьсан Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд “Тусгай мэдлэг бүхий мөрдөгч нь шинжилгээ хийж, магадлагаа гаргаж болно” гэсэн заалт оруулсан нь дээрх асуудлуудыг шийдэх нэгэн гарц болох бөгөөд хэрэв УИХ-аар батлагдан мөрдөгдөж эхэлбэл түүнийг хэрхэн зөв хэрэгжүүлэхээс үр дүн нь бүрэн хамаарах юм.

Мэргэжилтний үйл ажиллагаанд холбогдох нэгэн чухал чиг үүрэг бол шинжилгээ хийх явдал юм. Шүүх шинжилгээ хийх үйл ажиллагаа нь зөвхөн эрх бүхий албан тушаалтны тогтоол, захирамжаар шинжээчээр томилогдсон этгээдийн үйл ажиллагаагаар хязгаарлагддаггүй.

Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжоор тогтоосон хэм хэмжээний хүрээнд эрх бүхий субъект (хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүх, шүүгч, прокурор)-ийн тогтоол, захирамжаар хийж буй шинжилгээ, түүний үр дүнд бий болсон шинжээчийн дүгнэлт нь эрүүгийн хэргийн нотлох баримтын эх сурвалж болоход чиглэгддэг бол эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө, гүйцэтгэх ажлын арга хэмжээний үед эсвэл төрийн эрх бүхий зарим байгууллага гэмт хэргийн шинжтэй зарим асуудлыг шинжилгээгээр тодруулах шаардлага тулгардаг бөгөөд энэ нь эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдэх, сэжиглэл, таамаглал дэвшүүлэх, зохих байгууллагад шийдвэрлүүлэхээр шийдвэр гаргахад чиглэгддэг байна.

Үүнийг Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжоор хэм хэмжээ тогтоож шийдвэрлэсэн арга зам нь шинжилгээ хийж, магадлагаа гаргах хэлбэр бөгөөд Шүүхийн шинжилгээний тухай хуульд шинжилгээний магадлагааг төрийн эрх бүхий байгууллагын хүсэлтийг үндэслэн хийсэн анхан шатны үзлэг, оношлогооны үр дүнг тусгасан баримт бичгийг “шинжилгээний магадлагаа” гэнэ²² гэж тодорхойлжээ. Ингэхээр шинжилгээний магадлагаа буюу мэргэжилтний дүгнэлт нь нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэх үү? гэсэн асуудал гарч байна.

²¹ Б.Жаргалсайхан. Экспертийн дүгнэлт, түүний эрх зүйн зохицуулалт. Илтгэл.

²² Бө.Бат-Эрдэнэ. Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь шинжээч, мэргэжилтний оролцоо. Дисс. М., 2009.

Судалгаанаас үзэхэд ОХУ-ын процессийн хуульд мэргэжилтний дүгнэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлэхээр заасан²³ байна.

Докторант Б.Лхагвасүрэн "Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасныг үндэслэн эрх бүхий байгууллагын хүсэлтээр хийсэн шинжилгээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46.1²⁴-ийг зөрчих болдог учраас шинжээчийн дүгнэлт нь нотлох баримтын эх сурвалж болж чадахгүй"²⁵ гэсэн байна. Б.Лхагвасүрэн шинжилгээний эцсийн үр дүн болох шинжээчийн дүгнэлтийг мөрдөгч, шүүгч үнэлэхдээ харгалзаж үзэх шалгуур нь хууль зүйн шалгуур, шинжлэх ухааны шалгуур, техник шалгуур²⁶ гэж ангилсан байх бөгөөд үүн дээр хүний хүчин зүйлийн шалгуурыг нэмж, шинжээчийн дүгнэлт, шинжилгээний магадлагааг харьцуулж үзье.

Шалгуур	Шинжээчийн дүгнэлт	Шинжилгээний магадлагаа
Хууль зүйн шалгуур	Тогтоол, захирамжаар	Эрх бүхий төрийн байгууллагын хүсэлтээр
	Шинжээчээр томилогдсон, тусгай мэдлэг эзэмшсэн хүн байна	Тусгай мэдлэг эзэмшсэн байна
	Шинжээчид эрх, үүрэг, хариуцлагыг сануулдаг	Шаардлагагүй
	Хэрэв байгууллагын шинжээч бол байгууллагын тэмдгээр баталгаажуулна	Хувийн тэмдгээр баталгаажуулж болно
Шинжлэх ухааны шалгуур	Ялгаагүй	Ялгаагүй
Техникийн шалгуур	Дэлгэрэнгүй	Товч бичиж болно
Хүний хүчин зүйл	Тусгай мэдлэг эзэмшсэн хүн байна	Тусгай мэдлэг эзэмшсэн хүн байна

Ийм учраас "шинжилгээний магадлагаа" нь нотлох баримтын эх сурвалж болохгүй учраас энэ үйл ажиллагааг явуулах шаардлага байна уу? гэсэн асуудал тулгарч байна. Практикт тулгарч байдаг асуудлыг судлаж үзэхэд шинжээч томилж, дүгнэлт гаргуулах эрх зүйн болон цаг хугацааны боломж хязгаарлагдмал, тусгай мэдлэг ашиглан шийдвэрлэх асуудлын цар хүрээ бага, гэхдээ зайлшгүй шинжилгээгээр тодруулах, ингэснээр эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдэх, сэжиглэл, таамаглал дэвшүүлэх, шийдвэр гаргахад нөлөөлөх зүйл цөөнгүй тулгардаг. Үүний заримыг дурдвал:

- Эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх; Тухайлбал, хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ. Бид гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ гэж байгаа боловч бидний үзэж байгаагаар шийдвэрлэж байгаа асуудлаас дүгнэж үзвэл энэ нь үе шаттай хийгдэх шинжилгээ болох нь харагддаг. Энэ төрлийн шинжилгээний дүгнэлт нь "Гэмтлийн зэрэг тогтоох журам"-аар "гэмтлийн зэрэгт хамаарахгүй", "хөнгөн", "хүндэвтэр", "хүнд гэмтэл" гэж 4 ангилагддаг ажээ. Эндээс үзвэл хүний биед үүссэн гэмтлийн зэрэг нь гэмтлийн зэрэгт "хамаарна", "хамаарахгүй"

²³ Шүүхийн шинжилгээний тухай хууль. 6 дугаар зүйл.

²⁴ УПК РФ. Ст.74.

²⁵ ЭБШХ-ийн 46.1.Шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулахын тулд зохих байгууллагын шинжээч, тусгай мэдлэг бүхий, тухайн хэрэгт хувийн сонирхолгүй этгээдийг шинжээчээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоолоор, шүүгч захирамжаар томилно.

²⁶ Б.Лхагвасүрэн. Криминалистикийн шинжилгээ судлал. УБ., 2010. 23 дахь тал.

гэсэн 2 үндсэн шалгуурт хуваагдаж байна. Иймд эхлээд хамаарах, хамаарахгүй алин болохыг тогтоох нь чухал асуудал болж байна. Шүүхийн шинжилгээний байгууллагын статистик мэдээгээр 2015 онд улсын хэмжээнд гэмтлийн зэрэг тогтоох 31535 шинжилгээ хийснээс 26 хувь нь буюу бараг 1/3 нь гэмтлийн зэрэгт хамаарахгүй гэсэн дүгнэлт гарсан.²⁷ Энэ тоо баримтаас үзвэл энэ төрлийн хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах явцад 26 хувийг нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 175 дугаар зүйлд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 156 дугаар зүйлд хүний бие махбодид учирсан гэмтлийн зэрэг, шинж байдлыг тогтоох шинжилгээг заавал хийхээр заасан бөгөөд энэ нь үе шатны хувьд *нэгдүгээрт, гэмтлийн зэрэгт хамаарах гэмтэл үүссэн эсэхийг тогтоох, дараа нь түүнийг зэргийг тогтоох* гэсэн утгаар ойлгогдож байна. Үүнээс дүгнэлт хийхэд, цаг хугацаа, хүн хүч хэмнэх үүднээс хүний биед үүссэн гэмтэл нь “Гэмтлийн зэрэг тогтоох журам”-д заасан зэрэгт хамаарах эсэхийг эхний шатанд тодорхойлох зорилгоор эмч-мэргэжилтэн шинжилгээ хийж, магадлагаа гаргах бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, өнөөгийн нөхцөлд энэ тохиолдол нь хойшлуулшгүй ажиллагааны журмаар зохицуулагддаг, мөн заавал хийх шинжилгээний төрөлд ордог боловч хуулийн зохицуулалтыг судлаж, хууль хэрэглээг зөв төлөвшүүлснээр хүндрэлтэй байгаа асуудлыг шийдэж болно гэж үзэж байна.

- Гүйцэтгэх ажлын арга хэмжээний үед олж авсан баримт, мэдээллийг шалгах; Тухайлбал, гүйцэтгэх ажлын арга, хэрэгсэл ашиглаж олж авсан зүйл нь хар тамхи мөн эсэхийг тодруулах шаардлага тулгарахад Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46 дугаар зүйлд заасан журмаар шинжилгээ хийлгэх боломжгүй байдаг учраас мэргэжилтэнд хандаж магадлагаа гаргуулах хэрэгцээ бий болдог.

- Төрийн зарим байгууллага үйл ажиллагааныхаа явцад илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг тодруулах; Жишээ нь, Улсын бүртгэлийн газарт өөр хүний нэрээр иргэний үнэмлэх, паспорт гаргуулах гэсэн оролдлого байнга гардаг байна. Жилд дунджаар 120 орчим²⁸ энэ төрлийн зөрчлийг тодруулахаар буюу дүр зургийн шинжилгээ хийлгэхээр шинжилгээний байгууллагад хандсан тоо баримт байна. Энэ тохиолдолд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан журмаар шинжилгээ хийж, дүгнэлт гаргах боломжгүй байдаг.

- Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомж, байцаан шийтгэх ажиллагааны түүхэн практикийг судлаж үзэхэд өнөөдөр бидний өмнө тулгамдаж байгаа асуудлыг хэдийгээр иж бүрэн биш ч гэсэн шийдвэрлэж байсан жишээ олон байна. Тухайлбал, 1963 онд криминалист-хэрэг бүртгэгчийн орон тоог бий болгож 10 хүнийг тусгай сургалтаар бэлтгэж орон нутаг, дүүргийн цагдан сэргийлэх ангиудад томилон ажиллуулж байжээ.²⁹ Мөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн архивын материалаас үзэхэд эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнөх ажиллагааны үед эрх бүхий байгууллагын хүсэлтийг үндэслэн шинжилгээ хийж, магадлагаа гаргасан жишээ шинжилгээний байгууллагад цөөнгүй байна. Тухайлбал, 1989 онд 1096 шинжилгээ хийсний 3,3 хувьд нь магадлагаа гаргажээ.³⁰ Мэргэжилтэн (шинжээч) өөрийн санаачлагаар магадлагаа гаргах тохиолдол байжээ. Жишээ нь, 1980, 1990-ээд оны сүүл үе хүртэл дүүргийн цагдаагийн

²⁷ Шүүх шинжилгээний статистик 2014. УБ., 2015. 25 дахь тал.

²⁸ Шүүхийн шинжилгээний байгууллагын тайлан. 2002-2005 он.

²⁹ Т.Очирбат. Шинжлэн магадлахуй. УБ., 2014. 41 дэх тал.

³⁰ ЦЕГ-ын КШТ-ийн жилийн тайлан. 1990.

хэлтсийн шинжээчид хэргийн газрын үзлэгээр илрүүлж, бэхжүүлсэн гарын мөрийг тэнцэх, тэнцэхгүйгээр нь ялгасан эсвэл хохирогчийн гарын хээтэй харьцуулан шинжилсэн магадлагааг өөрийн санаачлагаар гаргаж өгдөг байсан. Харин 1997 оноос хойш шинжилгээ хийж, магадлагаа гаргасан тохиолдол байхгүй байна. Энэ нь магадлагаа гаргах шаардлагагүй болсон гэсэн үг биш бөгөөд магадлагаа гаргах ёстой тохиолдолд дүгнэлт гаргаж байсантай холбоотой. Тухайлбал, УБЕГ-аас шинжилгээ хийлгэхээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн "шинжээчийн дүгнэлт" гаргаж байсан нь хуулийг буруу хэрэглэж байжээ гэж тайлбарлахаас аргагүй.

Дүгнэлт, санал

Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах чиг үүрэг, шинжилгээ хийх чиг үүргийн хооронд үйл ажиллагааны орон зай үүссэн байна. Одоогийн мөрдөж буй эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн хүрээнд *зохион байгуулалтын өөрчлөлт, хуулийн гүйцээн зохицуулалт, боловсон хүчний хангалт хийх, хууль хэрэглээний зөв практик тогтоох* замаар энэ орон зайг зайлшгүй нөхөх шаардлагатай. Мөн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд боловсруулан УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн барьсан Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх хуулийн төсөлд дээрх асуудлыг шийдвэрлэхээр оруулсан заалтыг³¹ хэвээр үлдээх, мөн мэргэжилтний эрх зүйн байдлын талаар тодорхой тусгаж чадаагүй заалтыг нэмж оруулах боломжийг эрэлхийлэх нь судлаачдын үүрэг гэж үзэж байна.

Цаашид мэргэжилтний эрх зүйн байдлыг тодорхой болгож, практикт хуулийн зөв хэрэглээг бий болгосноор тулгамдаж буй дараах асуудлууд шийдэгдэнэ гэж үзэж байна.

Үүнд:

1. Шүүн таслах ажиллагаанд мэргэжилтнийг түлхүү оролцуулснаар шинжилгээг олон дахин хийлгэдэг байдал үгүй болно;

2. Иргэдийн эрх, эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлт шуурхай болж, гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний ачаалал буурч, иргэдийг чирэгдүүлэх явдал үгүй болно;

3. Зам тээврийн осол, хэргийн шийдвэрлэлтэд сайнаар нөлөөлнө. Мэргэжилтний идэвхтэй оролцоо бий болж, шинжилгээний магадлагаа, мэргэжилтний справка бий болгосноор хууль хэрэглэх асуудлаар шинжээч томилж, дүгнэлт гаргуулан³² хууль зөрчиж байгаа асуудал зогсоно;

4. Цагдаа, тагнуул, АТГ, УБЕГ, ИХШХЕГ зэрэг төрийн эрх бүхий байгууллагаас хүсэлт гарган хийлгэдэг шинжилгээний хариу хуулийн дагуу болно;

5. Нийслэлийн ШША-ны шинжээчид хэргийн газраас илрүүлсэн бүх төрлийн ул мөр, эд мөрийн баримтад мэргэжилтний хувиар шинжилгээ хийж, магадлагаа гаргаж өгөх боломжтой;

6. Ам зураг гаргах, полиграф шинжилгээ, үнэрийн шинжилгээний хариу өгөх хэлбэр боловсронгуй болно;

7. Шинжээч эмчийн илгээх бичгээр хийж буй бүх төрлийн шинжилгээний хариу нь шинжилгээний магадлагаа хэлбэрээр гарна. Шинжээч эмчийн хүсэлтээр

³¹ 5.2 дугаар зүйл. "Тусгай мэдлэг эзэмшсэн мөрдөгч энэ хуульд заасан шинжээч, мэргэжилтний эрхийг хэрэгжүүлж, магадлагаа гаргаж болно"

³² 2014 онд ЗЦГ-ын байцаагчид хуулийн зүйл, заалт зөрчсөн эсэх асуудлаар 1600 шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан байна.

мэргэжилтэн шинжилгээ хийж, магадлагаагаар хариу өгснөөр хууль зөрчигдөхгүй байх үндэс бүрдэнэ. Хими, биологи, ДНХ, бактериологийн чиглэлээр улсын хэмжээнд 2014 онд нийт 13551 шинжилгээ хийснээс 5831 шинжилгээг ШЭШХ-ийн болон аймгуудын ШША-ны шинжээч эмчийн илгээх бичгээр хийсэн байна;

8. Эд хөрөнгийн үнэлгээг эдийн засгийн шинжилгээгээр тогтоож шижилгээний магадлагаа байдлаар гаргах өгөх боломжийг үгүйсгэхгүй;

9. Эдийн засгийн шинжилгээг одоогоор эрх бүхий байгууллагын акт, дүгнэлт гарсны дараа хийх эрх зүйн зохицуулалттай. Шинжилгээний магадлагааг бий болгосноор эдийн засгийн асуудлаар анхан шатанд мэргэжилтэн хувиар хийж магадлагаа гаргаж оролцох боломж бүрдэнэ.

Юуны түрүүнд хамгийн тулгамдсан асуудлуудыг шийдэх дараах тодорхой саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Зохион байгуулалтын өөрчлөлт: Шүүхийн шинжилгээний байгууллагад эмч-мэргэжилтэн эсвэл цагдаагийн байгууллагад тусгай мэдлэгтэй мөрдөн байцаагч (жишээ нь эмч мэргэжилтэй мөрдөн байцаагч) бий болгож ажиллуулах. Өөрөөр хэлбэл, мөрдөн байцаагч, мэргэжилтэн гэдгийг хоёр тусдаа хүнээр ойлгож болох боловч тусгай мэдлэг эзэмшсэн, тухайлбал эмч мэргэжилтэй мөрдөн байцаагч байж болохыг хууль тогтоомжоор үгүйсгээгүй. Эдгээр мэргэжилтэн хэргийн газрын үзлэг хийхдээ мэргэжилтний үүргийг давхар гүйцэтгэх, шинжилгээ хийж магадлагаа гаргах, түүнийгээ үндэслэж эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх, сэжиглэл, таамаглал дэвшүүлэх, боломжтой.

ЭБША-нд өдөр тутам тулгардаг нэн тулгамдсан асуудлыг шийдэж болох тодорхой санал гэвэл, хүний биед үүссэн гэмтлийн зэрэг, шинж байдлыг тогтоох шинжилгээг “нэгдүгээрт, гэмтлийн зэрэгт хамаарах гэмтэл үүссэн эсэхийг тогтоох, дараа нь түүнийг зэргийг тогтоох” гэж ойлгохоор байна. Иймд иргэдийг чирэгдүүлэхгүй байх, цаг хугацаа, хүн хүч хэмнэх үүднээс хүний биед үүссэн гэмтэл нь гэмтлийн зэрэгт хамаарах эсэхийг эмч-мэргэжилтэн (тусгай мэдлэгтэй мөрдөн байцаагч) тодорхойлж магадлагаа гаргадаг, хэрэв гэмтлийн зэрэгт хамаарч байвал шинжээч томилох тогтоол үйлдэж гэмтлийн ямар зэрэгт хамаарах талаар дүгнэлт гаргуулдаг байх бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх боломжтой.

Өнөөгийн нөхцөлд энэ тохиолдол нь хойшлуулшгүй ажиллагааны журмаар зохицуулагддаг, мөн заавал хийх шинжилгээний төрөлд ордог боловч хуулийн зохицуулалтыг нь судлаж, хууль хэрэглээг зөв төлөвшүүлснээр хүндрэлтэй байгаа асуудлыг шийдэж болно гэж үзэж байна.

Хуулийн гүйцээн зохицуулалт: Хууль зүйн техникийн хувьд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд байцаан шийтгэх ажиллагаа явуулах ерөнхий нөхцөл, тулгуур ойлголтууд, харин салбар хуулиудад түүнийг гүйцээсэн зохицуулалт, харин салбарын үйл ажиллагааг зохицуулсан журам, зааварт үйл ажиллагааны нарийн дэг журмуудыг заах ёстой. Энэ судалгааны хүрээнд авч үзэж буй “мэргэжилтэн” түүний эрх зүйн байдал, мэргэжилтэн шинжилгээ хийж магадлагаа гаргах талаарх тулгуур ойлголтууд хуульд тэр болгон тусаагүй, зүйрлэж хэлбэл мэргэжилтний талаарх “эрээвэр хураавар” заалтуудыг байгууллагын журмаар гүйцээн зохицуулах боломж нь нээлттэй байна. Иймд “шинжээчээр томилогдож дүгнэлт гаргах”, “мэргэжилтнээр оролцож магадлагаа гаргах” журмыг боловсруулж батлуулах шаардлагатай байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 2002;
2. Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хууль. 2010;
3. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. 2010;
4. Бө.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь мэргэжилтэн, шинжээчийн эрх зүйн байдал. Дисс. М., 2009;
5. Ж.Болдбаатар. Гэмт хэрэг илрүүлэхэд полиграф ашиглах онол, арга зүйн асуудал. Дисс. УБ., 2013;
6. Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Ерөнхий анги. УБ., 2004;
7. Б.Жаргалсайхан. Экспертийн дүгнэлт, түүний эрх зүйн зохицуулалт. Илтгэл. 2010;
8. Д.Баярсайхан. эрүүгийн процессийн эрх зүй. УБ., 2014;
9. Т.Оюунчимэг. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь шинжилгээ. УБ., 2006;
10. Б.Лхагвасүрэн. Криминалистикийн шинжилгээ судлал. УБ., 2010;
11. Т.Очирбат. Шинжлэн магадлахуй. УБ., 2014;
12. Шүүхийн шинжилгээний байгууллагын тайлан. 2002-2005 он;
13. ЦЕГ-ын КШТ-ийн жилийн тайлан. 1990;
14. Шүүх шинжилгээний статистик 2013. УБ;
15. Шүүх шинжилгээний статистик 2014. УБ;
16. Т.В.Аверьянова. Судебная экспертиза. М., 2009;
17. Charles R. Swanson. Criminal Investigation. 1996;
18. Max M. Houck. Fundamentals of Forensic Science. 2006;
19. Michael M. Martin. New York Evidence Handbook: Rules, Theory, and Practice. 2002;
20. Уголовно-процессуальный кодекс Российской Федерации;
21. Федеральный закон "О государственной судебно-экспертной деятельности в Российской Федерации". 2001;
22. Forensic Examination Act. Estonia. 2001;
23. Canada Evidence Act. 1985;
24. БНХАУ-ын Эрүүгийн заргын хууль. 1996